



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТЕЗ-аас харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай
хуулийг хэрэгжүүлж ажиллах үүрэг чиглэл өгсөн боловч
хэрэгжилт, үр дүнг тооцоогүй байна

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СЭА-2025/21-17-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Утас: 70363040	Б.Батмөнх
2025 он	Аудитын менежер	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Утас: 70363036	Ц.Отгонбаяр
	Ахлах аудитор	Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.com
	Утас: 70363036	Б.Наранцэцэг
	Аудитор	Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn
	Утас: 70363036	

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
А бүлэг: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн зөрчил нийт зөрчлийн 78.0 хувийг эзэлж байна.	5
А.1. Нийт ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн 14 хувь нь бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.	5
А.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хориглосон заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс нийт 240.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.	7
Б бүлэг: ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	8
Б.1. Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн тодотголоор өөр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөж, баталсан байна.	9
Б.2. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх орчин нөхцөл хангалттай бүрдээгүйгээс төрийн байгууллагууд худалдан авалт хийгээгүй байна.	11
В бүлэг: ТЕЗ-аас харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах үүрэг чиглэл өгсөн боловч үр дүнг тооцож ажиллаагүй байна	12
В.1. Аймгийн ТЕЗ-ийн зүгээс харьяа байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.	12
В.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар төсвийн хөрөнгийн үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулалт тодорхой хэмжээгээр буурсан байна.	12
В.3. Зарим байгууллагууд нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлэхгүй орхигдуулах, хугацаа хоцроосон зөрчлийг давтан гаргасан байна.	13
Илрүүлсэн зөрчил	14
Дүгнэлт	14
Зөвлөмж	15
Ирүүлсэн санал, тайлбар	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТБОНӨХБАҮХА	Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэсэн байдал	5
Хүснэгт 2	Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2023, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт зөрчил	13
Хүснэгт 3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн шийдэл	14

Дүрслэлийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн төлөвлөгөө, гүйцэтгэл	7
Дүрслэл 2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн нийт зөрчил	8

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаал, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу? • Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу? • Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу?
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад аймгийн ТЭЗ-ийн харьяа бүх шатны төсвийн захирагчид орон нутгийн өмчит ААТҮГ зэрэг нийт 64 байгууллагын 2023-2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн баримт материалыг хамруулав.
Аудитын арга зүй:	Аудитыг АДБООС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд: • Монгол Улсын 2022, 2023, 2024 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, • Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Төрийн албаны тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,

	• Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”, • Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Барилга, байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт, • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор Б.Наранцэцэг нар 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 12-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ А. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН УУ?

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн зөрчил нийт зөрчлийн 78.0 хувийг эзэлж байна

А.1 Хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан уу?

Нийт ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн 14 хувь нь бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна

А.1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2¹, 5.3² дахь заалтын хүрээнд аймгийн ТЕЗ, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд нь дараах арга хэмжээг авснаар цалин, урамшуулал болон холбогдох бусад зардлыг 9.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнд:

- Нийгмийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч Ц.Рэгзэдмааг чөлөөлсөн,
- Аймгийн ИТХ-ын даргын зөвлөхөөр ажиллаж байсан Ж.Санжжавын гэрээг цуцалсан,
- Орон нутгийн өмчит байгууллагууд нь зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулаагүй гэх мэт.

А.1.2 Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4³ дахь заалтын хэрэгжилтийг ТЕЗ, түүний харьяа 45 байгууллагын ашиглаж буй 194 тээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэсэн эсэхийг тулган баталгаажуулахад 28 байгууллага нийт тээврийн хэрэгслийн 82.0 хувьтай тэнцэх 159 тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг солиулсан байна.

А.1.3 Харин 2024 оны жилийн эцсийн байдлаар тээврийн хэрэгсэл байгууллагын нэр дээр шилжигдээгүй, бичиг баримт дутуу, гээгдүүлсэн, оношилгоонд оруулаагүй болон 2024 онд шинээр бүртгэсэн гэх үндэслэлээр 17 байгууллага 35 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг солиулаагүй байсан бол 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 13 байгууллага 27 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг солиулах арга хэмжээ аваагүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралтаар харуулав/

А.1.4 Аймгийн ТЕЗ-ийн харьяа төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁴, 6.2⁵ дахь заалтыг хэрэгжүүлэн шатахууны зарцуулалтад хяналт тавьж ажилласнаар тээвэр, шатахууны зардлыг 2023 онд 412.7 сая төгрөгөөр, 2024 онд 166.8 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна. Шатахууны зардлын хэмнэлтэд дараах байгууллагуудын хэмнэлт голлон нөлөөлсөн байна. Үүнд:

¹ ... аймаг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно.

² ..., иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно.

³ Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

⁴ ... төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

⁵ аймаг, сумын ИТХ-ын дарга, Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

Төсвийн байгууллагууд:

- 2023 онд Сайхан сум 4.8 сая төгрөгөөр, Орхонтуул сум 5.4 сая төгрөгөөр, Шаамар сум 3.8 сая төгрөгөөр,
- 2024 онд Ерөө сум 8.4 сая төгрөгөөр, Зүүнбүрэн сум 7.0 сая төгрөгөөр, Сант сум 16.1 сая төгрөгөөр,

ААТҮГ-ууд:

- 2023 онд Сэлэнгэ энерго 358.3 сая төгрөгөөр, Тохилог хараа 11.1 сая төгрөгөөр, Цагаан эрэг тохижилт 20.7 сая төгрөгөөр,
- 2024 онд Гавшгай ус 9.1 сая төгрөгөөр, Сэлэнгэ энерго 69.8 сая төгрөгөөр, Тохилог хараа 12.4 сая төгрөгөөр, Цагаан эрэг тохижилт 21.1 сая төгрөгөөр гэх мэт.

А.1.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтаар цэргийн албан хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон байдаг.

Бид аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 онуудын санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нийцлийн асуудлыг хамтатган горим, сорил хэрэгжүүлэхэд дараах **1.9** сая төгрөгийн зөрчил илэрч, төлбөрийн акт тогтоож, хэрэгжилтийг хангуулсан болно. Үүнд:

- Мандал сумын ЗДТГ нь 2023 онд төсвийн хөрөнгөөр албан хаагчдад 32 ширхэг гар болон сагсан бөмбөгийн, ширээний теннисний тоглолтын хувцас худалдан авсан.

А.1.6 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1⁶ дах заалтын дагуу аудитын түүвэрт хамруулан шалгасан 12 орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын удирдах болон бусад албан тушаалтны үндсэн цалинг тогтоосон байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд аймгийн Засаг даргын захирамж болон сумын ИТХ-ын тогтоолоор 4 байгууллага, байгууллагын даргын тушаалаар 8 байгууллага нь удирдах болон бусад албан тушаалтны үндсэн цалинг тус тус тогтоосон байна.

Дээрх 12 орон нутгийн өмчит байгууллагууд нь удирдах албан тушаалтны үндсэн цалинг 2023 онд 0.9-2.5 сая төгрөгөөр, 2024 онд 1.2-3.0 сая төгрөгөөр, албан хаагчдын цалинг 2023 онд 0.5-1.8 сая төгрөгөөр, 2024 онд 0.7-2.5 сая төгрөгөөр тус тус харилцан адилгүй тогтоосон байна.

Энэ нь ижил хөдөлмөрт тэгш цалин олгогдох боломж алдагдах, ажлын хариуцлага, бүтээмжид сөрөг үр дагавар үүсгэх, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах эрсдэлийг үүсгэсэн байна.


А.1.7 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1⁷-д Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй гэж заасныг аудитад хамрагдсан байгууллагууд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

⁶ Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг ... орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

⁷ Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаас дээрх зардлын гүйцэтгэлийг харахад дээрх зардалд 2023 онд 369.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 287.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдаж 81.6 сая төгрөг, 2024 онд 594.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, 336.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдаж, 257.4 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Дүрслэл №1. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн төлөвлөгөө, гүйцэтгэл:



Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын хэмнэлт нь 2023 онд 4 байгууллагын 4 албан хаагч, 2024 онд 7 байгууллагын 10 албан хаагч өөрийн хүсэлтээр тэтгэвэрт гарахыг хойшлуулсан болон төрийн албан хаагчийн хүний нөөцийн дутагдалтай байгаагаас үргэлжлүүлэн ажиллаж байгаа зэргээс шалтгаалсан байна.

А.1.8 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4⁸-д зааснаар төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагууд хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг санхүүжүүлэхийг хориглосон байдаг.

А.1.9 Тус газраас 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийж гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах байгууллагуудад нийт **13.7** сая төгрөгийн зөрчил илэрч, албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна. Үүнд:

- Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь БНХАУ-д аялах аяллын зардалд 7.1 сая төгрөгийг,
- Аймгийн ИТХ нь нутгийн удирдлагын байгууллагад сонгогдож, томилогдож байсан ахмад, дунд, залуу үеийн төлөөлөгчдийн туршлага солилцох уулзалт арга хэмжээ зохион байгуулж, “Хонгор морьт” амралтад хүлээн авахад 6.6 сая төгрөгийг зарцуулсан гэх мэт.

А.2 Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан уу?


Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хориглосон заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс нийт 240.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна

⁸ 12.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.4 хуулиар зөвшөөрөөгүй бусад.

A.2.1 Тус газраас ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хориглосон заалтуудыг зөрчсөн нийт **240.7** сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгосон буюу 15.1.3⁹ дахь хориглосон заалтыг зөрчсөн нийт **51.1** сая төгрөгийн зөрчил илэрч, 26.5 сая төлбөрийн акт тогтоон 24.6 сая төгрөгийн албан шаардлага,
- Баримтат кино, видео контент хийлгэсэн буюу 15.1.4¹⁰ дэх хориглосон заалтыг зөрчсөн нийт **159.1** сая төгрөгийн зөрчил илэрч, албан шаардлага,
- Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн буюу 15.1.5¹¹ дахь хориглосон заалтыг зөрчсөн нийт **11.0** сая төгрөгийн зөрчил илэрч, албан шаардлага,
- Хэрэгцээ, шаардлагагүйгээр бараа материал нөөцөлсөн буюу 15.1.6¹² дахь хориглосон заалтыг зөрчсөн нийт **19.5** сая төгрөгийн зөрчил илэрч, албан шаардлага тус тус хүргүүлэн, зөрчлийг таслан зогсоосон байна.

Дүрслэл №2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн нийт зөрчил:



Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн зөрчлүүдийг ангилж, дүн шинжилгээ хийж үзэхэд нийт зөрчлийн 78.0 хувийг тус хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн зөрчил эзэлж байна.

Төсвийн байгууллагууд нь хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй, дээд шатны төсвийн захирагчаас өгсөн үүрэг, чиглэлийг биелүүлээгүйгээс 2024 онд зөрчил өмнөх оноос 2 дахин өссөн байна.

БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН УУ?

ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

Б.1 Хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан уу?

⁹ ... бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхийг хориглоно.

¹⁰ Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно.

¹¹ Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно.

¹² Нөөцлөх шаардлагатай бараа материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно.

Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн тодотголоор өөр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөж, баталсан байна

Б.1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3¹³, 13.1.5¹⁴-д худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх, төсөл, арга хэмжээний хуулиар батлагдсан төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг гаргахгүй байхаар зохицуулсан байдаг.

2024 онд тус газраас хийж, гүйцэтгэсэн “ОНХС-ийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”, “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн” сэдэвт аудитуудаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нийцлийн хүрээнд горим сорил хэрэгжүүлснээр дараах зөрчлүүд илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн байна. Үүнд:

- Мандал, Орхон сумын ОНХС-аар хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээний тендерийн хэмнэлт болох 30.8 сая төгрөгийг нэмэлт гэрээ байгуулж, зарцуулсан,
- Аймгийн ОНХО-ын эх үүсвэрээс хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй зураг төсөвт тусгагдаагүй зайлшгүй шаардлагатай нэмэлт ажлыг гүйцэтгүүлсэн гэсэн үндэслэлээр 118.6 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж, санхүүжүүлсэн гэх мэт.

Б.1.2 Аудитын явцад аймаг болон Сүхбаатар, Сайхан, Мандал, Ерөө сумдын ОНХО болон ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтэд дүн шинжилгээ хийхэд 2024 онд аймаг болон Ерөө сум нь худалдан авах ажиллагааны төсвийн хэмнэлтийг төсвийн тодотголоор өөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- Аймаг ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор 10 төсөл арга хэмжээний ХАА-ын үр дүнд бий болсон 115.2 сая төгрөгийн хэмнэлтийг гэрээний дүнгээр бууруулж, шинээр 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн,
- Ерөө сум нь сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 142 дугаар тогтоолоор 18 төсөл арга хэмжээний ХАА-ын үр дүнд бий болсон 117.3 сая төгрөгийн хэмнэлтийг гэрээний дүнгээр бууруулж, шинээр 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Б.1.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх "Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх" гэсэн заалтыг зөрчсөнөөс дараах төсөл, арга хэмжээнүүдийг он дамжиж хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна. Үүнд:

- 2023 онд аймаг, сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 926.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхийн 7 төсөл арга хэмжээний ХАА нь оройтож зарлагдсанаас шалтгаалан тайлант онд хэрэгжих боломжгүй болж он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан,

¹³ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх.

¹⁴ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх.

- 2024 онд аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор буюу тодотголоор 397.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхийн 6 төсөл арга хэмжээг аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр нэмж баталснаар ХАА нь оройтож, тайлант онд хэрэгжих боломжгүй болж он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан,
- 2024 онд Мандал сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 120.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний ХАА нь оройтож зарлагдсанаас, 570.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээг тодотголоор буюу сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 152 дугаар тогтоолоор нэмж , баталснаар ХАА нь оройтож, тайлант онд хэрэгжих боломжгүй болж он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан.

Б.1.4 Хэдийгээр тодорхой хэмжээний иргэдийн эрх ашигт нийцсэн боловч тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих бус төсвийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй, нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын болон дээврийн засварын 13 төсөл, арга хэмжээг 1,852.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ОНХС болон ОНХО-ын төлөвлөгөөнд төлөвлөж, хэрэгжүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3¹⁵: 13.3.2¹⁶-д заасныг зөрчиж байна. Үүнд:

- 2023 оны аймгийн ОНХС-ийн төлөвлөгөөнд 595.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ, Сүхбаатар сумын ОНХС-ийн төлөвлөгөөнд 429.3 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ,
- 2024 оны аймгийн ОНХО-ын төлөвлөгөөнд 328.1 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, аймгийн ОНХС-ийн төлөвлөгөөнд 250.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, Сүхбаатар сумын ОНХС-ийн төлөвлөгөөнд 250.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ.

Б.1.5 Аймаг, сумд нь ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн зөрчлүүдэд буюу 2023 оны хэрэгжилтэд 2024 онд хийгдсэн гүйцэтгэл, нийцлийн аудитаар албан шаардлага, зөвлөмж өгсөн бол 2024 оны зөрчлүүдэд 2025 онд энэ чиглэлээр бие даан хийгдэх аудитуудаар авч үзэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

- ОНХО-аар 2023, 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг төсвийн байгууллага, сумын Засаг дарга нараас хүлээн авсан боловч хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлээр эрэмбэлж, үнэлэх ажлыг хийгээгүй,
- ОНХО-аар 2023, 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техникийн нөхцөл аваагүй, зураг төсөвгүй болон төсөв батлагдсаны дараа батлагдсан төсөвт өртөгт нь багтаан зураг, төсвийг хийлгэсэн нийт 3,983.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 64 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан,
- Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналыг авч, эрэмбэлэгдээгүй 2,000.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээг 2023-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн,

¹⁵ Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:

¹⁶ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

- *Аймаг, сумын ОНХС-аас шинээр хэрэгжүүлэх нийт 6,115.0 сая төгрөгийн 62 төсөл арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгэжээ баталсан гэх мэт.*

Б.2 Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулж ажилласан уу?

Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх орчин нөхцөл хангалттай бүрдээгүйгээс төрийн байгууллагууд худалдан авалт хийгээгүй байна

Б.2.1 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1¹⁷-д заасны дагуу Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2023 онд 5, 2024 онд 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны захиалгын хуудсыг тус тус цахим системд илгээж, цахим дэлгүүрээс дараах худалдан авалтуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- *2023 онд ОНХО-ын эх үүсвэрээр хэрэгжсэн 75.0 сая төгрөгийн өртөг бүхий “Сум, тосгодын Соёлын төвийн тоног төхөөрөмж бэлтгэх” төсөл арга хэмжээнд 15 суурин компьютер 25 ш,*
- *Аймгийн ЗДҮАХХ-ийн батлагдсан төсвөөр хэрэгжсэн “Баг тосгоны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх /бүх багт/” хөтөлбөрийн хүрээнд 122.5 сая төгрөгийн өртөг бүхий 13 зөөврийн компьютер 57 ш,*
- *Улсын хэмжээний “Шилдэг аймаг”-аар шалгарсан шагналын эх үүсвэрээр хэрэгжсэн “Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг хангах” хөтөлбөрийн хүрээнд 76.8 сая төгрөгийн өртөг бүхий 15 суурин компьютер 24 ш, 17 суурин компьютер 1 ш, 13 зөөврийн компьютер 1ш,*
- *“Сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 41.4 сая төгрөгийн өртөг бүхий 13 зөөврийн компьютер 18 ш,*
- *Тендер шалгаруулалтын урилга хэвлүүлэх үйлчилгээ 1.4 сая төгрөг,*
- *2024 онд аймгийн ЗДҮАХХ-ийн төсвөөр хэрэгжсэн “Сумдад тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх ” хөтөлбөрийн хүрээнд 63.4 сая төгрөгийн өртөг бүхий 13 суурин компьютер 31 ш, 2.3 сая төгрөгийн өртөг бүхий олон үйлдэлт принтер 3ш,*
- *“Нийтийн номын сангууд болон СХДАА-нд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 63.9 сая төгрөгийн өртөг бүхий 15 зөөврийн компьютер 23 ш, 15 суурин компьютер 5 ш, олон үйлдэлт принтер 3ш гэх мэт.*

Б.2.2 Харин цахим дэлгүүрийн бараа бүтээгдэхүүний сонголт цөөн, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, захиалагч байгууллагын тавьсан шаардлагад нийцээгүй гэх үндэслэлүүдээр аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Б.2.3 Бид аудитын явцад цахим дэлгүүрээс худалдан авсан бараа, үйлчилгээний үнэ, өртөг, үр дүнд дүн шинжилгээ хийж үзэхэд 2023 онд компьютер, тоног төхөөрөмжийг нийлүүлэх компани цөөн, үнийн санал нь захиалгын үнээс ялгаагүй байсан бол 2024 онд нийлүүлэх аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж, үнийн санал нь захиалгын үнээс дунджаар 0.1-0.3 сая төгрөгөөр буурсан байдалтай байна.

¹⁷ Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна.

БҮЛЭГ В. ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН БУСАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮНТЭЙ БАЙСАН УУ?

ТЕЗ-аас харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах үүрэг чиглэл өгсөн боловч үр дүнг тооцоогүй байна

В.1 Хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд хяналтаа бүрэн хэрэгжүүлсэн үү?

Аймгийн ТЕЗ-ийн зүгээс харьяа байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна

В.1.1 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633, 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/776, 777, 778 дугаар албан бичгүүдээр шат шатны төсвийн захирагчид, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын дарга, удирдлагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, Шилэн дансны тухай болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг мөрдөх, төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах зэрэг нийт 18 чиглэлийн үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хагас бүтэн жилээр тооцон, тайланг ирүүлэхээр даалгасан байна.

В.1.2 Гэвч дээрх албан бичгээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн дүгнээгүй, үр дүнг тооцоогүй байна.

В.1.3 Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тусгайлан хяналт шалгалт хийж, гүйцэтгээгүй бол 2024 онд Сүхбаатар, Зүүнбүрэн сумдад хийгдсэн хяналт шалгалтаар нийт 118.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, албан шаардлага хүргүүлсэн байна.

В.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр хэмнэлттэй, үр ашигтай байсан уу?

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар төсвийн хөрөнгийн үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулалт тодорхой хэмжээгээр буурсан байна

В.2.1 Хэдийгээр аймгийн ТЕЗ-ийн зүгээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, үр дүнг тооцоогүй ч гэсэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төрийн аудитын байгууллагаас хийж гүйцэтгэсэн аудитын хүрээнд тодорхой хэмжээний үр дүн, арвилан хэмнэлт гарсан гэж дүгнэж байна. Үүнд:

- Албан ажлын хэрэгцээнд ашиглагдаж буй авто машинуудын ашиглалт, шатахуун зарцуулалтыг сайжруулсан, албан ажлын хэрэгцээнд авто машин нэмж худалдан аваагүй, дэд дарга, зөвлөхүүдийн албан тушаалыг цомхотгосон, сургалтуудыг цахимаар гүйцэтгэсэн, хөрөнгийн зардлуудыг танасан зэрэг шалтгаануудын улмаас Сэлэнгэ аймгийн батлагдсан төсвийн зарлага /аймаг, сумд нийлсэн дүн/ 2023 онд 15.7 хувиар, 2024 онд 19.0 хувийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.
- Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь МҮЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн

хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ын дагуу санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд 103.9 сая төгрөгийн, 2024 онд 215.6 сая төгрөгийн зөрчил тус тус илрүүлж, 30.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 289.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажилласнаар төсвийн хөрөнгийн үр ашиггүй, арвиан хэмнэлтгүй зарцуулалт энэ хэмжээгээр буурсан байна.

Хүснэгт №2: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Албан шаардлага			
		2023		2024		2023		2024		2023		2024	
		Тоо	мөнгөн дүн	Тоо	мөнгөн дүн	Тоо	мөнгөн дүн	Тоо	мөнгөн дүн	Тоо	мөнгөн дүн	Тоо	мөнгөн дүн
1	Төсвийн байгууллага	9	103.9	27	213.6	1	11.8	3	16.6	8	92.1	24	197.0
2	Орон нутгийн өмчит үйлдвэрүүд	-	-	1	2.0	-	-	1	2.0	-	-	-	-
	ДҮН	9	103.9	28	215.6	1	11.8	4	18.6	8	92.1	24	197.0

В.3 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан уу?

Зарим байгууллагууд нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлэхгүй орхигдуулах, хугацаа хоцроосон зөрчлийг давтан гаргасан байна.

В.3.1 Төсвийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зорилтот түвшин, түүний гүйцэтгэл, таван сая төгрөгөөс дээш худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэр, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн төсөл, тендерийн мэдээлэл зэрэг үзүүлэлтүүдийг тодорхой хугацааны давтамжтайгаар шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй.

В.3.2 Хэдийгээр аймгийн ТЕЗ-ийн зүгээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч холбогдох албан тушаалтнуудын хариуцлагагүй байдлаас мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлэхгүй байх, хугацаа хоцроож мэдээлэх зөрчлүүд давтагдан гарсаар байна.

В.3.3 Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийж гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны 731 мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлээгүй, 157 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлүүд илэрч 5 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 15 албан шаардлага, 24 зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт №3: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн аудитын шийдэл:

№	Байгууллагын төрөл	Үүнээс:							
		Нийт зөрчил		Сахилгын шийтгэл тооцох		Албан шаардлага		Зөвлөмж	
		2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
1	Төсвийн байгууллага /52/	14	12	5	-	4	7	7	5
2	Орон нутгийн өмчит /12/	9	7	-	-	2	2	7	5
	Нийт дүн	23	19	5	-	6	9	14	10

Үүнээс дүгнэхэд зарим байгууллагууд нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлэхгүй орхигдуулах, хугацаа хоцроох зэргээр холбогдох ажилтны хариуцлагагүй байдал, удирдлагын зүгээс тавих хяналт сул байгаагаас шалтгаалан зөрчил давтагдсан байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **4,099.0** сая төгрөгийн зөрчил илрүүлж, цаашид зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

- 13 байгууллага 27 автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй,
- Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтээр аймаг 115.2 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээ, Ерөө сум 117.3 сая төгрөгийн өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээг тус тус шинээр хэрэгжүүлэхээр төсвийн тодотгол хийсэн.
- Худалдан авах ажиллагааг оройтож зарласнаас 2023 онд аймаг болон бусад сумд 926.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээ, 2024 онд Мандал сум 120.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг он дамжин хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан,
- Төсвийн тодотголоор аймаг 2024 онд 397.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээг, Мандал сум 570.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээг төсвийн тодотголоор нэмж батлан он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан,
- Төсвийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй, нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын болон дээврийн засварын 1,852.4 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг аймаг, сумдын ОНХС болон ОНХО-ын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн ТЕЗ-ийн зүгээс харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг, даалгавар өгсөн боловч хэрэгжилтийг дүгнээгүй, үр дүнг үнэлээгүй, үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

- Аймгийн ТЕЗ-ийн зүгээс хуулийн хэрэгжилтийг нэгдсэн байдлаар үнэлж, дүгнээгүй ч авто тээврийн хэрэгслүүдийн ашиглалт, шатахуун зарцуулалт сайжирч, орон тоо хэмнэх, гадаад албан томилолтын зардал багасах зэргээр төсвийн үр ашиг, арвилан хэмнэлтгүй зардал буурсан байна.
- Сэлэнгэ аймгийн батлагдсан төсвийн зарлага / аймаг, сумд нийлсэн дүн/ 2023 онд 15.7 хувийн, 2024 онд 19.0 хувийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.
- Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон тендерийн хэмнэлтийг нэмэлт гэрээ байгуулан зарцуулсан бөгөөд төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын ажлуудыг нэмж баталсан зэргээс шалтгаалан төсөл арга хэмжээнүүдийг он дамжин хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна.
- Зарим байгууллагууд нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлэхгүй орхигдуулах, хугацаа хоцроох зөрчлийг давтан гаргасан байна.

ЗӨВЛӨМЖ

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:

- Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшинг харгалзан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдын цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоох,
- Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэхээр болон худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтээр өөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлахгүй байх.
- Төсвийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй төсөл, арга хэмжээг ОНХС болон ОНХО-ын төлөвлөгөөнд тусгаж, батлахгүй байх.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тогтоосон хугацаанд зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах замаар төлөвлөсөн төсөл арга хэмжээг тухайн жилд нь багтаан ашиглалтад оруулах.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхээр харьяа байгууллагад хүргүүлсэн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд үнэлж, дүгнэх, үр нөлөө бүхий дотоод хяналт, шалгалт хэрэгжүүлэх замаар зөрчлийг арилгах арга хэмжээ авах.
- Харьяа байгууллагуудын эзэмшилд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслүүдийг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болгох.
- Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийж, оршиж буй зөрчлийг арилгуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

Б.НАРАНЦЭЦЭГ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 байр, Их суварга 505.

Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081

Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn

Цахим хуудас: www.selenge.gov.mn

2025.05.08 № 01/594

танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Өгөгдсөн зөвлөмжийн талаар ажил зохион байгуулахыг холбогдох мэргэжилтнүүдэд үүрэг болгов.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Ж.САЙНЦОГ

432500822

C:\user\албан бичиг 2025\Засаг дарга жижиг тоот А5

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДЫН
БУСАД АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС ЯЛГАГДАХ ТОД ДЭВСГЭР ӨНГӨ БҮХИЙ УЛСЫН ДУГААРЫН СУДАЛГАА

Хавсралт 1

№	Шалгагдагч байгууллагын нэр	Ашиглагдаж буй машины тоо	Дугаар солиулсан машины тоо	Зөрүү	Тайлбар
1	Алтанбулаг сумын ИТХ	1	1	0	
2	Алтанбулаг сумын ЗДТГ	5	5	0	
3	Баруунбүрэн сумын ЗДТГ	6	6	0	
4	Баянгол сумын ЗДТГ	5	4	1	
5	Ерөө сумын Сумын ИТХ	1	1	0	
6	Ерөө сумын Сумын ЗДТГ	7	5	2	Бонго, Ланд 80 маркын автомашинуудын нэр шилжигдээгүйгээс
7	Ерөө сумын Бугант захирагчийн алба	9	3	6	Нэр шилжигдээгүйгээс 4, бичиг баримт дутуу 2 зэрэг нийт 6 тээврийн хэрэгсэл
8	Ерөө сумын Ерөө бүсийн ойн анги	1	1	0	
9	Жавхлант сумын ЗДТГ	8	7	1	
10	Зүүнбүрэн сумын ЗДТГ	7	6	1	Тээврийн хэрэгслийн бичиг баримтыг гээгдүүлсэн
11	Мандал сумын ЗДТГ	4	4	0	
12	Мандал сумын Түнхэл захирагчийн алба	2	0	2	Бичиг баримт дутуугаас
13	Мандал сумын Хэрх захирагчийн алба	1	1	0	
14	Мандал сумын Хараа бүсийн ойн анги	1	1	0	
15	Орхон сумын ЗДТГ	3	3	0	
16	Орхонтуул сумын ЗДТГ	6	6	0	
17	Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба	2	2	0	
18	Сайхан сумын ЗДТГ	3	3	0	
19	Сайхан сумын Номгон захирагчийн алба	1	1	0	
20	Сайхан сумын Хот тохижуулах газар	4	2	2	Хово маркын автомашины нэр шилжигдээгүйгээс
21	Сант сумын ЗДТГ	6	6	0	
22	Сүхбаатар сумын ИТХ	1	1	0	
23	Сүхбаатар сумын ЗДТГ	4	4	0	
24	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	3	3	0	
25	Түшиг сумын ЗДТГ	4	4	0	
26	Хушаат сумын ЗДТГ	2	2	0	
27	Хүдэр сумын ЗДТГ	6	4	2	
28	Цагааннуур сумын ИТХ	1	1	0	
29	Цагааннуур сумын ЗДТГ	8	5	3	2023 онд авсан галын машины гаалийн бичиг байхгүйгээс, хөрөнгө оруулалтаар ковш нийлүүлсэн байгууллагын албан бичиг, бохирын машин нь бичиг баримт дутуу зэргээс
30	Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги	1	1	0	
31	Шаамар сумын ЗДТГ	5	4	1	Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүйн улмаас автотээврийн төвөөс хүсэлтийг буцаасан
32	Шаамар сумын Дулаанхан захирагчийн алба	6	6	0	
33	Аймгийн ИТХ	2	2	0	
34	Аймгийн ЗДТГ	10	10	0	
35	Орон нутгийн өмчийн газар	1	1	0	
36	Байгаль орчны газар	2	2	0	
37	Цагаан Эрэг тохижилт үйлчилгээ	11	11	0	
38	Тохиллог хараа ААТҮГ	10	9	1	Тээврийн хэрэгслийн нэр шилжигдээгүйгээс шалтгаалсан
39	Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ	2	2	0	
40	Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ	2	1	1	Тээврийн хэрэгслийн торгуулийг төлөөгүйн улмаас дугаар солиулаагүй
41	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ	5	5	0	
42	Сэлэнгэ Цэнгэг Ус ОНӨААТҮГ	12	12	0	
43	Мандал энерго ОНӨААТҮГ	2	2	0	
44	Цант Орхон ОНӨААТҮГ	6	6	0	
45	Гавшгай ус ОНӨААТҮГ	5	1	4	Тээврийн хэрэгслүүд нь хувь хүний нэр дээр бүртгэлтэй буюу нэр шилжигдээгүйгээс
	НИЙТ	194	167	27	